

## СҮМБЭ ХАМБА ИШБАЛЖИРЫН “ГАЛБАРВААСАН МОДОН ” ЗОХИОЛЫН ТУХАЙ

С.ТАЙВАНСҮРЭН

**Товч агуулга:** Сүмбэ хамба Ишбалжир (1704-1788)-ын туурвисан Монголын түүхийн зохиолуудын дотроос нэлээд нэрд гарч, алдаршсан нь “Галбарваасан модон” хэмээх зохиол юм. Энэ өгүүлэлд Сүмбэ хамба Ишбалжирын “Галбарваасан модон” хэмээх сурвалжийн судалгааны тойм байдал, сурвалж бичгийн онцлогийн тухай өгүүлэхийг зорив.

**Түлхүүр үг:** Сүмбэ хамба Ишбалжир, Галбарваасан модон, Чойнжун, Номын гаргалга, Шашны түүх, Сүмбийн бурханы шашны түүх

### *Нэг. Сурвалжийн судлагдан, нийтлэгдсэн байдал*

Сүмбэ хамба Ишбалжир (1704-1788)-ын “Галбарваасан модон” зохиол бол түвэд хэл дээр бичигдсэн түүхийн чухал ач холбогдолтой томоохон бүтээлийн нэг юм. Тиймээс ч энэхүү зохиол нь олон улс орны эрдэмтдийн анхаарлыг татаж, түүнийг судлан шинжлэх ажил эрчимтэй өрнөсөн билээ.

*Өрнө дахин дахь судалгаа.* XIX зууны дунд үед Казаний Их Сургууль нь эрдэм шинжилгээний ажилтан, профессор О.М.Ковалевскийн тусламжтайгаар Орос дахь Монгол судлалын төв болсноор Орос дахь буддын шашин судлалын үндэс тавигдсан юм. Түүнийг үндэслэгч нь академич В.П.Васильев ажээ. Тэрээр 1840-1850 оны үед Бээжинд судалгаа хийж, түвэд ба хятад хэл дээр буддын шашны талаар маш их хэмжээний, Европын буддын шашин судлаачдын мөрөөдөж ч чадахааргүй хэмжээний зохиол бүтээл олж ирсэн байна. В.П.Васильев Сүмбэ хамбын “Галбарваасан модон” зохиолыг анх орос хэлнээ орчуулан судлах ажлыг хийсэн боловч, түүний бүтээл нь хэвлэгдэж, нийтийн хүртээл болоогүй ажээ. Түүний орчуулсан бүтээл эдүгээ ОХУ-ын ШУА-ийн Дорно дахины хүрээлэнгийн номын сангийн Ази судлалын архив дахь тус зохиогчийн бусад гар бичмэлийн хамт хадгалагдаж байна.

В.П.Васильевийн хэвлэгдээгүй зохиолыг нягтлан үзэж, судалсан хүн бол А.И.Востриков юм. Тэрээр бичихдээ “В.П.Васильевийн “Түвэдийн бурханы

шашны түүх” хэмээх хэвлэгдээгүй зохиол нь “Хэдэн зүйл урьдчилсан тэмдэглэл”, “Сүмбэ хамбын зохиолоос авсан ишлэлүүд”, “Он дарааллын хүснэгт” гэсэн гурван бүлэгтэй. Энэ орчуулга В.П.Васильевийн “Төвдийн бурханы шашны түүх” хэмээх хэвлэгдээгүй бүтээлийнх нь хамгийн гол гуравдугаар бүлгийг эзэлж байгаа юм. Энэ бүтээлийн нэгдүгээр бүлэг “Хэдэн зүйл урьдчилсан тэмдэглэл” нэртэй. Хоёрдугаар бүлэг “Сүмбэ хамбын зохиолоос авсан ишлэлүүд” нэртэй бөгөөд Төвдийн улс төрийн түүхийн тухай бүлгийг мөнхүү Сүмбэ хамбын зохиолоос орчуулахдаа эхээс нь нэлээд хазайлгаж, бас орхиж, зарим хэсгийг орчуулан, зарим хэсгийг өөрийн үгээр найруулсан байна”<sup>1</sup> гэжээ.

Харин Р.Е.Пубаев өгүүлэхдээ “В.П.Васильевийн архивын судалгааны дүгнэлтээс харахад Сүмбэ хамбын “Он дарааллын хүснэгт”-ийг орчуулан түүнийгээ “Галбарваасан модон” зохиолын хоёрдугаар бүлэгт оруулсан байна. Эндээс дүгнэхэд В.П.Васильевийн гар бичмэлийн “Түвэдийн бурханы шашны түүх” бүтээлийн нэгдүгээр бүлэгт Түвэд дэх бурханы шашны түүхийн судалгааг түвэдийн түүхчдийн ажилд үндэслэн бичиж, хоёрдугаар бүлэгт нь орчуулгын туршлагын тухай ба “Галбарваасан модон” зохиолын улс төрийн түүхийн хэсэг, хамгийн сүүлийн гуравдугаар бүлэгт “Он дарааллын хүснэгт”-ийн орчуулгыг багтаажээ. В.П.Васильевийн “Түвэдийн бурханы шашны түүх” зохиол нь түүнийг Оросын Түвэдийн түүхийн зохиолын судалгааны анхдагч байсан гэдгийг батлан харуулдаг. Тэрээр “Галбарваасан модон” зохиолын судалгааны ажлыг С.Ч.Дасаас нилээн эрт эхэлсэн юм. “Түвэдийн бурханы шашны түүх” зохиол нь дээр өгүүлсэнчлэн тухайн цаг үедээ хэвлэгдээгүй боловч уг зохиол нь энэтхэг, түвэд судлаачийг нэр хүндтэй болгосон. В.П.Васильев анх удаа түвэд судлалын түүхэн дурсгал “Галбарваасан модон”-г өндрөөр үнэлжээ. Хөх нуурын Сүмбэ хамбын гайхамшигт “Галбарваасан модон” зохиолтой учирлаа хэмээн бичжээ. Уг зохиол нь энэтхэг, хятад, түвэд, монгол дахь бурханы шашны түүх юм. Энэтхэгийн хувьд Даранатагийн олон алдааг залруулж, Түвэдийн хувьд он дарааллын хүснэгтийг зохиосон, Монголын хувьд бурханы шашны түүхийг бичсэн төдийгүй тухайн үеийн түүхэн үйл явдлын тухай өгүүлсэнээрээ ихээхэн үнэ цэнэтэй юм”<sup>2</sup> хэмээв.

1962 онд Оросын эрдэмтэн А.И.Востриков “Түвэдийн түүхийн зохиол” хэмээн бүтээлийг туурвижээ. Тэрээр энэхүү зохиолдоо Сүмбэ хамба Ишбалжирын “Галбарваасан модон” зохиолыг онцлон дурдаж, тус зохиолыг орчуулсан

<sup>1</sup> Востриков, А.И. *Төвдийн түүхийн зохиол*. Орос хэлнээс орчуулсан Д.Бүрнээ. Улаанбаатар: 2015, 232

<sup>2</sup> Пубаев, Р.Е. *“Пагсам-Чжонсан”-памятник тибетской историографии XVIII века*. Новосибирск: 1981, 14

В.П.Васильевийн хэвлүүлээгүй бүтээлтэй танилцаж, дүгнэн бичжээ. Тэрээр энэ тухай бичихдээ “В.П.Васильевийн орчуулгатай нарийн танилцаж үзвэл алдаа доголдол мэр сэр байх бөгөөд тус орчуулгын хийж байсан эрт дээр цагийг анхаарч үзвэл ойлгож уучлах бүрэн боломжтой юм. Эх зохиол дахь олон мэдээ товч, бас товчилсон үг орсон тул В.П.Васильев ойлгож чадаагүй буруу ташаа орчуулжээ. Товчлолыг тэр бээр огт тайлаагүйгээс гадна ямарваа зүүлт тайлбарыг орчуулгадаа хийсэнгүй. Гэсэн хэдий ч энэхүү эртний боловсруулаагүй орчуулга С.Ч.Дасын хэвлүүлсэн орчуулгаас харьцуулалтгүй илүү болсон юм”<sup>1</sup> хэмээн үнэлсэн байна.

Буриадын Нийгмийн Шинжлэх Ухааны Хүрээлэнгийн Дорно дахиныг судлах хэлтсийн эрдэмтэн Р.Е.Пубаев 1960 оноос эхлэн Сүмбэ хамба Ишбалжирын “Галбарваасан модон” зохиолыг тусгайлан судалж, хэд хэдэн эрдэм шинжилгээний өгүүлэл бичиж, улмаар 1981 онд ““Галбарваасан модон”-XVIII зууны түвэдийн түүх бичлэгийн дурсгал”<sup>2</sup> хэмээх сэдвээр түүхийн ухааны докторын зэрэг хамгаалж, энэхүү эрдмийн зэрэг горилж бичсэн зохиолоо удалгүй ном болгон хэвлүүлжээ. Тэрээр 1991 онд “Галбарваасан модон”-Түвэдийн түүхийн он дараалал”<sup>3</sup> нэртэйгээр хэвлүүлжээ. Р.Е.Пубаев “Галбарваасан модон” зохиолын тухай бичихдээ “Сүмбэ хамба “Галбарваасан модон” зохиолдоо эртний ба дундад зууны үеийн бурханы шашин дэлгэрсэн Зүүн Азийн томоохон улс байсан Энэтхэг, Түвэд, Хятад, Монголын шашин-улс төрийн түүхийг өгүүлжээ. Энэ үндсэн дээр эртний үеэс XVIII зууны дунд үе хүртэлх Умард, Төв, Зүүн Азийн улс орнуудын түүхийг илэрхийлсэн гэж хэлж болно. Дундад зууны үеийн төлөөлөгч Сүмбэ хамба Азийн орнуудын түүхийг бичихдээ ашиглаж болох бүх эх сурвалжуудыг ашиглаж, өмнөх үеийнхний санал бодолд шүүмжлэлтэй хандаж аль нэг улс төр, үндэстэн угсаатан, шашны асуудалд өөрийн гэсэн үзэл бодолтой хандаж байжээ. Сүмбэ хамба Эртний Энэтхэг ба дундад зууны Түвэд, Монголын шашин-улс төрийн шастирт шүүмжлэлтэй хандсан илэрхийлэл нь “Галбарваасан модон” зохиолын үг бүрт шингэсэн ба энэ байдал нь өөр нэг “Захидал харилцаа” бүтээлд хэсэгчлэн илэрхийлэгджээ. Түвэд, Монголын дундад зууны түүхийн шүүмжлэлтэй чиглэлийн томоохон төлөөлөгчдийн нэг бол Сүмбэ хамба мөн. “Галбарваасан модон” зохиолыг туурвихдаа, зарим нэг он дарааллын бичиг хэт зөрчилтэй байдаг, зарим нь их боловч бага утга агуулсан байдаг юм. Иймд Энэтхэг,

<sup>1</sup> Востриков, А.И. *Төвдийн түүхийн зохиол*. Орос хэлнээс орчуулсан Д.Бүрнээ. Улаанбаатар: 2015, 233

<sup>2</sup> Пубаев, Р.Е. *“Пагсам-Чжонсан”-памятник тибетской историографии XVIII века*. Новосибирск: 1981

<sup>3</sup> Пубаев, Р.Е. *Пагсам-Чжонсан: История и хронология Тибета*. Новосибирск: 1991

Түвэд, Хятад, Монголын шашин төрийн түүхийг үнэн зөв, дэс дараалсан байдлаар илэрхийлэхийг Сүмбэ хамба зорьжээ”<sup>1</sup> гэсэн байна.

Сүмбэ хамба Ишбалжирын “Галбарваасан модон” зохиолын тухай Италийнтүвэдч эрдэмтэн Жузеп Тучи өгүүлэхдээ “Эртний сурвалж бичигт нарийн гярхай сонголт хийж, өгүүлэн буй сэдэв нэг бүртээ үндсэн тулгуур бичгүүдээс эш татаж энэхүү зохиолоо бичжээ. Тэрээр Буддын үзэл санаа бүрэлдэн тогтож, дэлгэрснийг харуулж чадах нэвтэрхий толь бичихийг зорьжээ... Энэ бол үнэхээр дэлгэрэнгүй нэвтэрхий толь юм...Зохиолын үнэ цэнэ нь он дарааллын бичиг, домог, хутагт хувилгаадын намтар, улс төрийн үйл хэрэг, мөн шашны номлолыг багтаасан түвэдийн бүхий л түүхэн уламжлалыг нэгтгэн дүгнэсэнд оршино”<sup>2</sup> гэжээ.

Сүүлийн үед англи хэл дээр Сүмбэ хамбын “Галбарваасан модон” зохиолын тухай хэд хэдэн эрдэм шинжилгээний өгүүлэл хэвлэгджээ. Тухайлбал, Ханун Ким<sup>3</sup>, Ж.В.дэ Жон<sup>4</sup> нарын өгүүлийг дурдаж болно.

*Дорно дахин дахь судалгаа.* Сүмбэ хамба Ишбалжирын “Галбарваасан модон” зохиолын судалгаанд Энэтхэгийн эрдэмтэд чухал үүрэг гүйцэтгэжээ. Энэхүү зохиолыг анх шинжлэх ухааны эргэлтэд оруулсан хүн бол Сарат Чандра Дас юм. Тэрээр түүхч, хэл судлаач бөгөөд “Бенгалийн Азийн нийгэмлэгийн сэтгүүлтэй” хамтарч ажилладаг байжээ. Түүний намтар харьцангуй бага судлагдсан байна. Энэ эрдэмтний тухай анхны мэдээллийг В.В.Рокхил “Лхас ба Төв Түвэд рүү аялсан нь”<sup>5</sup> зохиолын удиртгалд дурджээ. Харин 1969 онд Калькут хотод С.Ч.Дасын “Намтар”<sup>6</sup> хэвлэгдсэн байна. Энэхүү “Намтар”-ын удиртгалд түүний тухай товч мэдээлэл байдаг. Тэнд өгүүлснээр түүнийг Санкт-Петербург дахь Хааны Археологийн Нийгэмлэгийн сурвалжлагч гишүүн байсан бөгөөд 1917 онд нас барсан гэжээ.

С.Ч.Дасын түвэд судлалын бүтээлүүд нь олон нийтэд танигдсан бөгөөд түүний зохиосон “Түвэд-Англи толь бичиг”<sup>7</sup> нь эдүгээ хүртэл түвэд судлаачдын ширээний ном болсоор байна. Тэрээр “Галбарваасан модон” зохиолын мэдээллийн үндсэн

<sup>1</sup> Пубаев, Р.Е “Пагсам-Чжонсан”-памятник тибетской историкографии XVIII века. Новосибирск: 1981, 14

<sup>2</sup> Tucci, G. *Tibetan Painted Scrolls*. Vol. I, II. Rome: 1949

<sup>3</sup> Hanung Kim. Sum-pa Ye-shes-dpal-'byor and the Civil War of Eighteenth Century Tibet: A Preliminary Essay on Ye-shes-dpal-'byors Many Roles in Tibetan Civilization. Current Issues and Progress in Tibetan Studies. Kobe City University of Foreign Studies, 2013

<sup>4</sup> J.W.de Jong. “Sum-pa mkhan-po (1704-1788) and his works”, *Harvard Journal of Asiatic Studies*, Vol. 27 (1967), 208-216

<sup>5</sup> Das S.Ch. *A Journey to Lhasa and Central Tibet*. London: 1902

<sup>6</sup> Das S.Ch. *Authobyography. Narratives of the incidents of my early life*. Calcutta: 1969

<sup>7</sup> Das S.Ch. *A Tibetan-English Dictionary with Sanskrit Syon-nym*s. Calcutta: 1902

дээр “Түвэд-Англи толь бичиг”-ийн ихэнх улс төрийн шинжтэй мэдээллүүдийг эмхтгэсэн ажээ. Түүний “Галбарваасан модон” бүтээлийг В.П.Васильеваас бараг 50 жилийн дараагаар судалж эхэлсэн боловч түүний судалгааны ажил нь ач холбогдол, үр дүнтэй болсон юм.С.Ч.Дасын Түвэд хэл дээрх түүхийн зохиол бүтээлүүдийг судлах ажилд гаргасан гол амжилт бол Сүмбэ хамба Ишбалжирын “Он дарааллын хүснэгт”<sup>1</sup>-ийг англи хэл рүү орчуулсан орчуулга (1886 он), “Галбарваасан модон”<sup>2</sup>зохиолын зохиолчийн товч намтрыг нийтэлсэн (1889 он), “Галбарваасан модон”<sup>3</sup> зохиолын I, II бүлгийг хэвлүүлсэн (1908 он) нь уг зохиолыг түвэдч эрдэмтдийн хүртээл болгож, шинжлэх ухааны эргэлтэд оруулсан явдал билээ. Гэвч түүний бүтээлүүд нь нягт нямбай бус ажил болсныг эрдэмтэд шүүмжлэн өгүүлсэн байдаг. Энэ тухай Оросын эрдэмтэн А.И.Востриков бичихдээ “Энэхүү зохиолыг шинжлэх ухаанд танилцуулсан нь С.Ч.Дасын гавьяа бөгөөд тэр нь “Галбарваасан модон” зохиолын I, II бүлгээс товчлон орчуулсанд оршино. Гэвч энэ орчуулга ч бай, түүний бусад зохиол нь хааш яаш байдалтай, бүхэл бүтэн үг орхиж, үгийн утгыг гажуудуулах гэх мэт олон алдаатай байсан. Ийм боловч бид С.Ч.Дасд талархах үүрэгтэй, түвэд судлаачдын өргөн хүрээнд энэ чухал дурсгалыг нээж, судалгаа шинжилгээг эхлүүлжээ”<sup>4</sup> гэсэн байна.

Харин Оросын эрдэмтэн Р.Е.Пубаев түүний ажлыг гурван зүйлээр тодорхойлон бичихдээ “Нэгд, С.Ч.Дас олон алдаа гаргасан ч, Сүмбэ хамбын намтар түүх, түүний бүтээлүүдийн жагсаалтыг мэргэжилтнүүдэд танилцуулсан нь түүний шинжлэх ухааны өмнө хийсэн ач тус. Гэвч энэ гавьяаг хэн ч тоогоогүй. Хоёрт, С.Ч.Дас “Галбарваасан модон” зохиолын текстийг хэвлүүлэхдээ дурсгалын найруулгыг тодорхойлон их ажил хийсэн, бичиг судлалын хэд хэдэн асуудлыг шийдсэн. Гуравт, С.Ч.Дас “Галбарваасан модон” зохиолын үндсэн дээр “Түвэд бол Монголын колони”, “Түвэдийн сүүлийн хаадын үед”, “Далай ламын шатлан захирах ёс” зэрэг хэд хэдэн өгүүллүүдийг хэвлүүлсэн. Энэхүү өгүүллүүд нь Түвэдийн түүхийн судалгаанд “Галбарваасан модон” зохиолыг ашиглах эхлэл тавигдсан”<sup>5</sup> хэмээн дүгнэсэн байна.

<sup>1</sup> Das, S.Ch. “The Tibetan Chronological Table “Reu-humig” from the original work Chos-Joongjon sang”, *JASB*, 1886

<sup>2</sup> Das, S.Ch. “Life of Sum-pa Khan-po also styled Ye-sesdPalhbyor the author of the Reu-himig (Chronological Tables)”, *JASB*, 1889

<sup>3</sup> Das, S.Ch. Sum-pa Khan-po Ye-sesdPal-`byor. dPag-bsamljon-bzangals History of Buddhism in India and Tibet. Vol. I-II. Calcutta, 1908

<sup>4</sup> Востриков, А.И. *Төвдийн түүхийн зохиол*. Орос хэлнээс орчуулсан Д.Бүрнээ. Улаанбаатар: 2015, 233

<sup>5</sup> Пубаев, Р.Е. “Пагсам-Чжонсан”-памятник тибетской историографии XVIII века. Новосибирск: 1981, 22-23

Монголын эрдэмтэн Ш.Бира бичихдээ “Ишбалжирын алдарт зохиол “Чойнжун”-г мөн Чандра Дас хэвлүүлжээ. Гэвч Чандра Дас Сүмбэ хамба болон түүний зохиол бүтээлийн талаар бичихдээ олон удаа ташаарсныг тэмдэглэх нь зүйтэй. Тэрээр Сүмбэ хамбыг түвэдийн эрдэмтэн гэж үзсэн нь эндүүрсэн хэрэг юм. Ч.Дасын энэхүү эндүүрлийг орчин үеийн судлаач (проф Г.Туччи, Л.Петех гэх мэт) одоо хүртэл давтаж Сүмбэ Хамбыг түвэдийн эрдэмтэн хэмээн түүний бүтээлийг түвэдийн утга зохиолд хамааруулсаар байна. Бид энэхүү үзлийг хүлээн зөвшөөрөх аргагүй юм. Учир нь Сүмбэ хамба Ишбалжир түвэд хүн биш харин түвэдээр зохиолоо бичдэг монгол хүн байсан болно”<sup>1</sup> гэжээ.

1959 онд Энэтхэгийн эрдэмтэн Локеш Чандра “Галбарваасан модон” зохиолын хятад, монгол он дарааллын хүснэгттэй III, IV бүлгийг хэвлүүлжээ<sup>2</sup>. Тэрээр 1975 онд Сүмбэ хамба Ишбалжирын 8 боть бүрэн зохиолыг бар эхээс нь хуулбарлан хэвлүүлсэн байна<sup>3</sup>.

1964 онд Энэтхэгт Та-лам Намжимдорж “Галбарваасан модон” зохиолын нэг бүлгийг “Сүмбэ хамбын Энэтхэгийн түүх”<sup>4</sup> нэртэйгээр хэвлүүлсэн ажээ.

Монгол эрдэмтэд XIX зууны сүүл үеэс Сүмбэ хамба Ишбалжирын “Галбарваасан модон” зохиолыг монгол хэлнээ орчуулан судалж эхэлжээ. Уг зохиолын зарим хэсгийг анх хуучин монгол бичгээр орчуулан, тайлбарласан хүн бол Цу голын дацанд XIX зууны сүүлийн хагаст амьдарч байсан Өвөр Байгалын хязгаарын буриад Галсанжамба Дэлгэров юм. 1869 онд Г.Ж.Дэлгэровын “Галбарваасан модон” зохиолын орчуулга нь модон барын аргаар хэвлэгджээ. Эдүгээ Г.Ж.Дэлгэровын Сүмбэ хамбын “Галбарваасан модон” зохиолын хоёр орчуулга бидэнд мэдэгдэж байна. Үүнд: “Бурханы шашны үзэл баримтлалын тухай – “Сав шимертөнцийн байдал ба анх тогтсон ёсны номлол оршивой”, Монголын түүхийн тухай – “Тэнгэрээс заяат Чингис хааны домог” ажээ. Тэрээр энэ хоёр зохиолоо 1869 онд орчуулсан байна.

Г.Ж.Дэлгэровын энэхүү орчуулгын зохиолын тухай Оросын эрдэмтэн Р.Е.Пубаев дүгнэн үзэхдээ “Дэлгэров өөрийн зохиолдоо мөр доор нэмэлт мөр оруулан “хийдийн” гэж нэрлэж болох тайлбар бичиг хийж түүндээ түвэд үгийг

<sup>1</sup> Бира, Ш. *Монголын түвэд хэлт түүхийн зохиол (XVII-XIX)*. Улаанбаатар: 2001, 23

<sup>2</sup> Sum-pa mkhan-po. dPag-bsamljon-bzang of Sum-pa mkhan-po ye-shesdpal'-byor. P. III containing a history of Buddhism in China and Mongolia preceded by rehu-mig of chronological tables edited by Dr.L.Chandra, with a foreword by prof. G.Tucci and preface by prof.L.Petech. New Delhi: 1959

<sup>3</sup> Collected works of Sum-pa-mkhan-po. Volume I-VIII.Reproduced by Lokesh Chandra. New Delhi: 1975

<sup>4</sup> Sum-pa mkhan-po. History of India. Edited be Ta-bla-ma. Delhi: 1964

монголоор орчуулж үсгийн дуудлагыг ялгах цэг тавьж өгчээ. Г.Ж.Дэлгэровын орчуулга нь монгол буриадын зохиол бүтээлийн хоорондын холбоонд тодорхой үүрэг гүйцэтгэсэн юм. Гэсэн ч энэ чухал буриадын соёлын өвийн талаар одоогийн байдлаар мэргэжилтнүүд ямар нэгэн судалгааны ажил хийгээгүй байна. Ийм учраас Г.Ж.Дэлгэровын орчуулга, зохиол бүтээлийн, зохиолын хэвлэлийн ажлын талаар судалгаа хийх шинжлэх ухааны шаардлага байгаа нь дамжиггүй юм”<sup>1</sup> гэжээ.

Монгол Улсын Үндэсний номын сангийн сан хөмрөгт хадгалагдаж буй Сүмбэ хамба Ишбалжирын “Галбарваасан модон” зохиолын түвэд хэл дээрх модон барын эхийг тус номын сангийн ахмад бичээч Лувсандорж сийрүүлэн хуулбарлан бичжээ<sup>2</sup>. Гэвч түүний сийрүүлэн хуулбарласан эх хэвлэгдэж гараагүй бөгөөд номын сангийн сан хөмрөгт хадгалагдаж байна.

Монгол улсын эрдэмтэд Сүмбэ хамба Ишбалжирын намтар, зохиол бүтээлүүдийг анхааран үзэж, өөрсдийн бүтээлүүддээ хамруулан судалжээ. Монгол улсын эрдэмтдээс анх Сүмбэ хамба Ишбалжирын “Галбарваасан модон” зохиолыг судалж, зохиол бүтээлдээ дурдсан хүн бол Ш.Бира юм. Тэрээр 1960 онд “Монгольская тибетоя зычная историческая литература (XVII-XIX)”<sup>3</sup> хэмээх өгүүллийг орос хэлээр бичиж хэвлүүлжээ. Энэхүү өгүүлэлдээ Сүмбэ хамба Ишбалжирын “Галбарваасан модон” зохиолын бар хэвлэл, судалгааны тойм, бүтэц, агуулгын тухай товч бичжээ. Мөн 2001 онд бичиж, хэвлүүлсэн “Монголын түвэд хэлт түүхийн зохиол” хэмээх бүтээлдээ Сүмбэ хамба Ишбалжирын намтар, түүхийн зохиол бүтээлүүдийн тухай тусгай бүлэг бичжээ. Ш.Бира бичихдээ “Сүмбэ хамбын Чойнжун нь эрт үеэс монгол болон түвэд хэлээр зохиолоо бичдэг монгол түүхчдийн гол сурвалж хэрэглэгдэхүүн нь болсоор ирсэн тул монголын түүх бичлэгт ихээхэн нэрд гарсан зохиол болно. Сүмбэ хамбын энэ зохиол нь монгол түүхчдийн хожуу үеийн зохиолд их нөлөө үзүүлжээ. Үүнээс үүдэн Сүмбэ хамбын зохиолыг нарийвчлан судлах нь эрдэм шинжилгээний хувьд их ач холбогдолтой юм...Тус зохиол нь үзэл санаа, улс төрийн хувьд үзэл суртлын үндэс нь бурханы шашин байсан хуучин монгол түүх бичлэгийн хүрээнээс халин гарч чадаагүйг тэмдэглэх хэрэгтэй. Мэдээжээр энэхүү зохиол зөвхөн хуучин монгол түүх бичлэгийн төдийгүй, ер нь бүхий л дундад зууны түүх бичлэгийн нийтлэг дутагдлаас ангижирч чадаагүй байсан нь ойлгомжтой. Сүмбэ хамбын Чойнжуны

<sup>1</sup> Пубаев, Р.Е. “Пагсам-Чжонсан”-памятник тибетской историографии XVIII века. Новосибирск: 1981, 28-29

<sup>2</sup> Бира, Ш. Монголын түвэд хэлт түүхийн зохиол (XVII-XIX). Улаанбаатар: 2001, 28-29

<sup>3</sup> Бира, Ш. Монгольская тибетоя зычная историческая литература (XVII-XIX). Улаанбаатар: 1960

үнэ цэнэ нь түүхэн үйл хэргийг тайлбарласандаа биш, харин түүхийн баялаг хэрэглэгдэхүүн агуулсандаа оршино”<sup>1</sup> гэжээ.

Д.Дагвадорж 1998 онд бичсэн “Монголын гүн ухааны мэргэдийн зохиолын цомирлог” бүтээлдээ Сүмбэ хамба Ишбалжирын намтар, түүхэн зохиолууд дахь гүн ухааны үзлийг судлан бичсэн байна. Тэрээр “Галбарваасан модон” зохиолын тухай өгүүлэхдээ “Сүмбэ хамба Ишбалбир “Галбарваасан модон” зохиолдоо түүхэн хөгжлийн үе шат хийгээд Азийн улс түмэнд бурханы шашин үүсч, хөгжсөн зүй ёсыг өмнөх үеийн мэргэдийн үзэл санааг залгамжлан, нийгмийн асуудал хийгээд төрийн ба улс төр, шашин номын ёсон үүсэж хөгжсөнийг нийгэм-улс төр, гүн ухааны үүднээс дэлгэн тавьсан нь түүний нийгэм-улс төр хийгээд шашны үзэл санааны гол агуулгыг илэрхийлдэг юм”<sup>2</sup> гэжээ.

Сүмбэ хамба Ишбалжирын “Галбарваасан модон” зохиол дахь түүхийн гүн ухааны асуудлуудыг судалсан хүн бол Б.Болд юм. Тэрээр 1990 онд хамтран бичиж хэвлүүлсэн “Монголын философийн түүхийн зарим асуудал” бүтээлдээ “Сүмбэ хамба Ишбалжирын нэгэн бүтээл дэх түүхийн философийн зарим асуудал” хэмээх тусгай бүлгийг бичсэн байна. Тэрээр бичихдээ “Бидний авч үзэж байгаа Сүмбэ хамбын зохиолд тэр үеийн сэтгэгчдийн бүтээлүүдэд түгээмэл үзэгдэх шашны зан үйл, хэв ёсны цэвэр ариун байдлыг хамгаалах, түүнд харшлах элдэв согог гажуудлыг шүүмжлэн, засаж сайжруулах гэсэн өнгө аяс байхын зэрэгцээ буддын философийн догматик зарчмаар нийгмийн үзэгдлийг тайлбарладаг концепцыг хөндөж, шүүмжилсэн хандлага нэлээд тодорхой гарч байна”<sup>3</sup> хэмээжээ.

Сүмбэ хамбын “Галбарваасан модон” зохиолын судалгаанд Өвөр Монгол, Хятадын эрдэмтэд онцгой анхаарч, эрдэм шинжилгээний олон бүтээлүүдийг туурвижээ. 1993 онд Өвөр Монголын Өөртөө Засах Орны номын санд хадгалагдаж байсан хулсан үзгийн бичмэл орчуулгын эхийг Цэнгэл, Бао жү нар харгуулан тайлбарлаж, Өвөр Монголын Өөртөө Засах Орны цөөн тоот үндэстний эртний ном бичгийг эмхтгэн найруулах комиссоос эрхлэн, Өвөр Монголын Ардын Хэвлэлийн Хорооноос хэвлүүлсэн байна. Тэд энэхүү зохиолын монгол орчуулгыг түвэд модон барын эхтэй харгуулж, 435 тайлбар, зүүлт хийж, “Ишбалжирын бурханы шашны түүх”<sup>4</sup> хэмээх нэртэйгээр хэвлүүлсэн нь “Галбарваасан модон” зохиолын судалгаанд чухал ач холбогдолтой ажил болжээ.

<sup>1</sup> Бира, Ш. *Монголын түвэд хэлт түүхийн зохиол (XVII-XIX)*. Улаанбаатар: 2001, 29-30

<sup>2</sup> Дагвадорж, Д. *Монголын гүн ухааны мэргэдийн зохиолын цоморлог*. Улаанбаатар: 1998, 85

<sup>3</sup> Болд, Б. “Сүмбэ хамба Ишбалжирын нэгэн бүтээл дэх түүхийн философийн зарим асуудал”, *Монголын философийн түүхийн зарим асуудал*. Улаанбаатар: 1990, 171

<sup>4</sup> *Ишбалжирын Бурханы шашны түүх*. Цэнгэл, Бао жү харгуулан тайлбарлав. Өвөр Монголын Ардын Хэвлэлийн Хороо: 1993



1992 онд Гань сү-гийн Үндэстний Хэвлэлийн Хорооноос Сүмбэ хамба Ишбалжирын “Галбарваасан модон” зохиолыг түвэд хэлээр “Сүмбийн бурханы шашны түүх” (藏文: 甘肃民族出版社, 1992年)<sup>1</sup> нэртэйгээр хэвлүүлсэн байна.

Хятадын түвдэч эрдэмтэн Пү вэнь чэн (蒲文成-pu wen cheng) 1994 онд Сүмбэ хамба Ишбалжирын “Галбарваасан модон” зохиолыг түвэд хэлнээс хятад хэл рүү анх удаа орчуулж, тайлар хийснийг Гань сү-гийн Үндэстний Хэвлэлийн Хорооноос эрхлэн “Рү и бао шү ши буюу Галбарваасан модны түүх” (如意宝树史-gu yi bao shu shi)<sup>2</sup> нэртэйгээр хэвлүүлжээ. Үүнийг 2012 онд засварлан дахин хэвлэхдээ “Сүмбийн бурханы шашны түүх” (松巴佛教史-song ba fu jiao shi)<sup>3</sup> нэртэйгээр хэвлүүлсэн байна. Ийнхүү хятад хэлээр хэвлэгдсэнээр Хятадын эрдэмтэн судлаачдын анхаарлыг татаж, уг зохиолыг олон талаас нь нягтлан судлах боломжийг нээж өгчээ. Пү вэнь чэн бичихдээ ““Рү и бао шү ши (如意宝树史-gu yi bao shu shi) бол Сүмбэ хамбын зохиолуудын нэг бөгөөд түвэд хэл дээрх түүхийн зохиолуудын дунд ихэд алдартай зохиол юм. Уг зохиолыг бүхлээр нь авч үзвэл бурханы шашин Энэтхэг болон манай улсын түвэд үндэстэн, монгол үндэстэн түүнчлэн Хятад оронд дэлгэрсэн тухай баялаг түүх, үлгэр домог гэх мэт түүхийн асар их материалуудыг хураангуйлан өгүүлсэн, түүхэн цаг үеийг алдаа эндүүрлийг засаж залруулсан, Энэтхэгийн бурханы шашны түүх, Түвэд үндэстний түүх, уламжлалт бурханы шашны түүх, Монголын түүх зэргийг судлахад үнэ цэнэтэй сурвалж бичиг болно”<sup>4</sup> гэжээ.

Дундад улсын эрдэмтэн, судлаачид Сүмбэ хамба Ишбалжирын намтар, зохиол бүтээлүүдийг сонирхон судалж, олон арван эрдэм шинжилгээний өгүүллүүдийг бичиж хэвлүүлжээ. 2016 онд Цэнгэл, Улаангэрэл нарын судлаачид Сүмбэ хамба Ишбалжирын намтар, зохиол бүтээлүүдийн тухай гадаад, дотоодын эрдэмтдийн бичсэн өгүүллэгүүдийг эмхтгэн “Ишбалжирын судалгааны өгүүллийн түүвэр”<sup>5</sup> хэмээх нэрээр хэвлүүлсэн байна.

Өвөр Монгол, Хятадын эрдэмтэд Сүмбэ хамба Ишбалжирын “Галбарваасан модон” зохиолын тухай хэд хэдэн эрдэм шинжилгээний өгүүллийг бичиж хэвлүүлжээ. Тухайлбал, Чойжи “Монголын түүхэн сурвалж бичгийн товч тайлал”<sup>6</sup>,

<sup>1</sup> 藏文: 甘肃民族出版社, 1992年

<sup>2</sup> [清] 松巴堪布·益西班觉著; 《如意宝树史》, 蒲文成才让译, 甘肃民族出版社, 1994年

<sup>3</sup> [清] 松巴堪布·益西班觉著; 《松巴佛教史》, 蒲文成才让译, 甘肃民族出版社, 2012年

<sup>4</sup> [清] 松巴堪布·益西班觉著; 《松巴佛教史》, 蒲文成才让译, 甘肃民族出版社, 2012年002页。

<sup>5</sup> *Ишбалжирын судалгааны өгүүллийн түүвэр* (益西班觉研究论集). Цэнгэл, Улаангэрэл нар найруулав. Үндэстний Хэвлэлийн Хороо: 2016

<sup>6</sup> 乔吉《蒙文历史文献要览》, 内蒙古社会科学, 1986年第6期

Гүй рун (贵荣) “Сүмбэ хамба Ишбалжирын “Бурханы шашны түүх””<sup>1</sup> Улаан “Сүмбэ хамба Ишбалжир хийгээд Ойрад Монголын түүхийн судлал”<sup>2</sup>, “Сүмбэ хамба Ишбалжирын “Галбарваасан модон” зохиолын тухай нэмж бичив”<sup>3</sup> ”Сунь линь (孙林) “Сүмбэ хамба Ишбалжирын “Галбарваасан модон”, бас түүний Түвэдийн түүхийн судалгаанд эзлэх байр суурь”<sup>4</sup>, Чэнь чин инь (陈庆英), Жан зи лин (张子凌) нарын “Сүмбэ хамба ба түүний “Галбарваасан модон” зохиолын судалгаа”<sup>5</sup>, Инь вэй сиань (尹伟先), Цэн шүэ мэй (曾雪梅) нарын “Гадаад дахь “Галбарваасан модон” зохиолыг судалгааг үнэлэх нь”<sup>6</sup>, Жан зи лин (张子凌) “Түвэд хэл дээрх түүхийн зохиол “Галбарваасан модон” сурвалжийн үнэ цэнийг өгүүлэх нь”<sup>7</sup>, Лиү жао (刘超), Ма вэнь тао (马文涛) “Түвэд хэл дээрх “Галбарваасан модон” зохиол дахь Монголын хаадын угсаа залгамжлалын тэмдэглэл дэх түүхэн материалын үнэ цэнийг задлан шинжлэх нь”<sup>8</sup> зэрэг өгүүллүүдийг дурдаж болно.

Сүмбэ хамба Ишбалжирын “Галбарваасан модон” зохиолын судлагдсан байдалд дүн шинжилгээ хийж үзэхэд тус зохиолын шүүмжлэлт эх бичвэр, эх бичвэрийн тусгайлсан судалгаа, эрдэм шинжилгээний орчуулга, тайлбар, зүүлт, түүхийн чухал дурсгал болох талаар бүрэн судалгаа хийгдээгүй болно. Иймээс дараах хэдэн саналыг тэмдэглэж байна. Үүнд: Нэгд, В.П.Васельев, Г.Ж.Дэлгэров, С.Д.Дас, Р.Е.Пубаев, Л.Чандра нарын орчуулга, эрдэм шинжилгээний ажилд тусгайлан шүүмж өгч, үнэлэлт дүгнэлт өгөх шаардлагатай байна. Хоёрд, сүүлийн үеийн түүхийн шинжлэх ухааны онол, арга зүй, ялангуяа сурвалж судлалын ухааны тусгай арга зүйгээр “Галбарваасан модон” зохиолыг судлан шинжлэх ажил чухал болжээ. Гуравт, орчин үеийн шинжлэх ухааны түвшинд “Галбарваасан модон” зохиолыг эрдэм шинжилгээний орчуулга, тайлбар зүүлт хийж дахин шинээр хэвлүүлэх шаардлагатай байна.

<sup>1</sup> 贵荣《松巴堪布·益希班觉著《佛教史》》，蒙古学信息，1993年第2期

<sup>2</sup> 乌兰《松巴堪布·益西班觉著与卫拉特蒙古史学》，西部蒙古论坛，2008年2期

<sup>3</sup> 乌兰《松巴堪布对《如意宝树史》补撰》，北方民族大学学报(哲学社会科学版)，2009年6期

<sup>4</sup> 孙林；《松巴堪布·益西班觉的《如意宝树史》及其在藏族史学史中的地位》。孙林《藏族史学发展史纲要》，中国藏学出版社，2006年，第402-415页

<sup>5</sup> 陈庆英，张子凌；《对松巴堪布及其《如意宝树史》的研究》。格日勒主编《纪念柳陞祺先百年诞辰暨藏族历史文化论集》，中国藏学出版社，2008年

<sup>6</sup> 尹伟先，曾雪梅；《国外《如意宝树史》研究评价》。《西藏民族学院学报》，2011年，第6期

<sup>7</sup> 张子凌；《论藏文史籍《如意宝树史》的文献价值》。《西藏民族学院学报》，2011年，第6期

<sup>8</sup> 刘超，马文涛；《试析藏文史籍《如意宝树史》所记载蒙古世系的史科价值》，濮阳职业技术学院学报，2009年，第22卷第4期

### *Хоёр. Сурвалжийн эх зохиол ба орчуулга*

Сүмбэ хамба Ишбалжирын “Галбарваасан модон” зохиол нь түвэд хэлээр 317 хуудастай, судрын хэлбэртэй томоохон түүхийн зохиол юм. Энэхүү зохиолын үндсэн хоёр бар эх уламжлагдаж иржээ. Түүний нэг нь Монгол Улсын Улсын Төв Номын Сангийн сан хөмрөгт хадгалагдаж байна. Энэхүү бар эхийн цаасны хэмжээ 60x10,9 см, барын хэмжээ 54x8,4 см, мөрийн тоо 6-7, хуудасны тоо 316 ажээ<sup>1</sup>. Тус зохиолын нэг хуулбар эх Монгол Улсын Улсын Төв Номын Сангийн сан хөмрөгт хадгалагдаж байна.

“Галбарваасан модон” зохиолын гурван янзын монгол орчуулга байдаг. Нэг дэх нь XIX зууны сүүлийн хагаст амьдарч байсан Буриадын Дэлгэров гэгч ламын орчуулга юм. Тэрээр “Галбарваасан модон”-г орчуулахдаа зарим хэсгийг нь таслан авч “*Сав шим ертөнцийн байдал ба анх тогтсон ёсны номлол оршивой*”, “*Тэнгэрээс заяат Чингис хааны домог оршивой*” хэмээх хоёр дэвтэр болгосон байна. Г.Ж.Дэлгэровын “Сав шим ертөнцийн бүтэц, түүний анх тогтсон ёсны номлол оршивой” нь 13 хуудас жижиг хэмжээтэй (44x9 см) модон барын хэвлэл. Сүүлийн хуудсандаа ““Сав шим ертөнцийн бүтэц, түүний анх үүссэн дараалал”-ыг Сүмбэ хамбын “Галбарваасан модон” зохиолыг үндэслэн могой жилийн хаврын дунд сарын 11 -нд бичсэн Чимба нэрт Онон-Цу голын дацны өчүүхэн би болой” гэжээ. Энэхүү бүтээл нь “Галбарваасан модон” зохиолын бүрэн гүйцэд орчуулга биш, зохиогчийн зарим нэг тайлбартай хураангуй өгүүлэл юм. Монголчуудын түүхийн тухай өгүүлсэн “Тэнгэрээс заяат Чингис хааны домог” гэж нэрлэсэн “Галбарваасан модон” зохиолын хэсгийг орчуулсан Дэлгэровын орчуулга нь түүх судлалын чиглэлээр ихээхэн сонирхол татна. Энэхүү модон бар хэвлэл нь бага (44x9 см) хэмжээтэй 20 хуудастай. Хуудас бүр нь 29 мөртэй. Модон бар хэвлэл дээр “Гонлун хийдийн лам Сүмбэ-Хамба бичиж” Хүслийг биелүүлэгч гайхамшигт мод” гэж нэрлэсэн түүхээс Чингис хааны тухай, Монголд шашин дэлгэрсэн түүхийн тухай энэхүү домгийг Онон-Цу голын Вагин-Дара-Сумади-Бадра-Дан XV жарны шороон могой жилийн (1869 он) тэргүүн сарын 15-нд самбар дээр бичиж үлдээв” гэж тэмдэглэжээ<sup>2</sup>.

Хоёр дахь орчуулгын эхийг 1958 онд Өвөр Монголын Түүх, хэл бичиг судлах газрын судлаач Шинэнойрворчуулжээ<sup>3</sup>. Тэрээр тус зохиолын эхлэл хэсгээс

<sup>1</sup> Бира, Ш. *Монголын түвэд хэлт түүхийн зохиол (XVII-XIX)*. Улаанбаатар: 2001, 28

<sup>2</sup> Пубаев, Р.Е. “*Пагсам-Чжонсан*”-*памятник тибетской историографии XVIII века*. Новосибирск: 1981, 25, 29

<sup>3</sup> *Ишбалжирын Бурханы шашны түүх*. Цэнгэл, Бао жү харгуулан тайлбарлав. Өвөр Монголын Ардын Хэвлэлийн Хороо: 1993, 6



### ***Дөрөв. Сурвалжийн зохиогдсон он***

Сүмбэ хамба Ишбалжир XIII равжунгийн шар луу жил Гүнлүн Жамбалин хийдэд сууж байхдаа “Галбарваасан модон” зохиолоо бичиж дуусгасан тухайгаа зохиолынхоо төгсгөл үгэнд тэмдэглэжээ. Тэнд өгүүлсэн нь “*Тийн язгуурт хүрдэдийн дөрвөн цаг бүрнээ хоцроод Шамбалын оронд түүний язгуурт Тийн дарагч хэмээх хаан бээр ном үзүүлснээс хорин нэгэн жил одсон арван гуравдугаар Сайтар болсны шар луу жилд (1748 он), Сакьяагийн тойн Ишбалжир бээр их тангуудын дундах Гонлун хийдэд найруулсны бичигч ахуй гол ёсны маш хэтэрхий өгүүлэгч Равжамба дархан Лувсансамдан болой. Бичигч Лувсансамдан хийгээд хэв эхүй сийлүүлэгч Данзандонров нугууд. Үүнд хичээсэн буянаар нас урт болон ном хийгээд эд таваар дэлгэрч, Сокавадын оронд төрөөд түргэн бурханы хутгийг олох болтугай. Өлзий хутаг орших болтугай*”<sup>1</sup> гэжээ.

Үүнээс үзэхэд уг сурвалж бичгийг 1748 онд найруулан бичсэн нь тодорхой байна.

### ***Тав. Сурвалжийн зохиогч***

Сүмбэ хамба Ишбалжир (1704-1788) бол XVIII зууны Монголын гүн ухааны сэтгэлгээний томоохон төлөөлөгч, бурханы шашны гарамгай зүтгэлтэн төдийгүй түүх, гүн ухаан, шашин судлал, зурхай, хэл шинжлэл, анагаах ухааны чиглэлээр олон арван зохиол бүтээл туурвисан Монголын нэрт соён гэгээрүүлэгч эрдэмтэн хүн билээ.

Тэрээр өөрийн төрсөн газар орон, угсаа гарал, төрсөн он жилийн тухай “Өөрийн намтар”-таа тодорхой өгүүлжээ. Тэнд өгүүлсэн нь “*Миний мэндэлсэн орон газар нь зүүн зүгийн их амгалантай Амдуу зүгийн газрын хуваарь болох Богд Лувсандагбын илтдэн адистаглагдсан газар Зонха хэмээх урт нуурын дээд хэсэг лүгээ шадар ойр Хөх нуурын Тэшогжалмо хэмээн алдаршсан баруун этгээд Их Хатан голын хөвөөнөө баруун тийшээ эрчилсэн дун хэлбэртэй өчүүхэн толгой буйн урд талын хот мандал мэт монголоор Толь хэмээх нэртэй тал газар тэр бөлгөө. Яс угсаа минь Ер Замбуутивийн зүүн хойд хийгээд зүүн талын Согбо хийгээд Хор хэмээх Монгол хийгээд Ойрад хоёрын буйн урдахь нь дөчин есөн хошуу ба Халх долоон хошуу буй. Тэдгээрийн хаад, ноёдын угсаа сурвалжийн зонхи нь Зүүнгар хааны угсаа сурвалж бөлгөө...Түүнээс эхлэн Хөх нуурыг Ойрадууд барин өнөө маргаашийг хүртэл сууж буй ноёд түшимэд нь тэр хааны сурвалж мөн бөлгөө.*

<sup>1</sup> *Ишбалжирын Бурханы шашны түүх*. Цэнгэл, Бао жү харгуулан тайлбарлав. Өвөр Монголын Ардын Хэвлэлийн Хороо: 1993, 753-754

Энэ бүхнийг дашрамдуулан айлтгахын зэрэгцээгээр миний эцгийн сурвалж нь ноёлог угсаатан мөн бөгөөд Дөрвөн Ойрадын Баатуд хэмээх сурвалжит овогтон билээ. Эхийн минь овогч Зүүнгарын ноёдын сурвалж мөний тул яс угсаа нь ноёлог язгууртан мөн бөлгөө. Тиймийн тулд эцэг Дорждаш тайж хэмээх төвд хэл бичигт ихэд мэргэшсэн ба сэтгэлийн үндэс нь шулуун шударга, амны уншлагыг үргэлж уншдаг нэгэн ба эх Дашицо хэмээх энэ нутгийн ихэнхи хүмүүс элдэв зүйлийг асуун сурагладаг, их мэргэн, сэтгэл нь зөөлөн...нэгэн бөлгөө...Гэтэлгэгч хэмээх модон бичин жилийн намар найман сарын арван тавны нар ургахуй луу цагт нярайлсан дунд зэргийн биетэй хөвгүүн би бөлгөө”<sup>1</sup>хэмээжээ. Үүнээс үзвэл Сүмбэ хамба Ишбалжир нь 1704 онд Хөх нуурын Тольт хэмээх газарт Ойрад Монголын Баатуд овгийн язгууртан Дорждашийн дөрөвдүгээр хөвгүүн болон мэндэлжээ.

Эцэг, эхийнх нь сүсэг бишрэл, мэдлэг боловсрол нь түүнийг эрдэм номын мөр хөөхөд ихээхэн нөлөөлжээ. Тэрээр 3 наснаасаа сахил хүртэж, тойн болж, 4 настайдаа Цагаан Хадын Толь хийдийн Цоохор гэлэнд шавилан ном заалгасан байна.

1710 онд хоёрдугаар жанжаа хутагт Агваанлуvsанчойдон (1648-1744) Ишбалжирыг хувилгаан хэмээн таалж, 1712 онд түүнийг Сүмбэ гэгээн Лувсанданзанжамцын хувилгаан хэмээн тодруулж, “Сүмбэ номон хан” хэмээн нэр хүртээж, Гонлун хийдийн Чойрт залан суулгажээ. Хожим нь Сүмбэ хамба хэмээх нэрээр алдаршсан байна. Энэхүү “Сүмбэ” хэмээх нэрийн тухай Ишбалжир өөрөө тайлбарлан бичихдээ “Түвэдийн 18 их овгийн нэгийг “Сүмбэ” хэмээдэг”<sup>2</sup> гэжээ.

Сүмбэ хамба Ишбалжир Жанжаа Ринбуучий Агваанчойжин, Тууган гэгээн Чойжамц нараар ном заалгаж зурхай, отчийн ёсонд суралцан, улмаар цанид дацанд Чойрын ёсонд мэргэжиж эхэлжээ. Тухайн үеийн нийгмийн тодорхой шалтгаанаар Чин улсын цэрэг Хөх нуурын газар нутгийг түрэмгийлэх үед Ишбалжир Түвдэд зайлан хүрч Лхасын Чойрын дацан болон Брайван хийдэд 7 жил суралцан Билиг барамид, Абхидхарм, төв үзэл тэргүүтэн Чойрын таван боть зарлигт мэргэшин Линсрай гавж цол хүртжээ. Тэрбээр түвдийн үйзанд хүрч Ванчин Эрдэнэ Лувсаништэй (1633-1737) уулзан зөвлөгөө авч шашин номын ёсыг дэлгэрүүлэх үйлст зүтгэн 1726 онд Брайван хийдийн Гомон дацанд тэргүүн хамбаар өргөмжлөгдөж байжээ<sup>3</sup>.

<sup>1</sup> Сүмбэ хамба Ишбалжир. *Сүмбэ Ишбалжирын Өөрийн намтар оршивой*. Төвд хэлнээс орчуулж, удиртгал тайлбар бичсэн Л.Тэрбиш. Улаанбаатар: 2011, 11-15

<sup>2</sup> Сүмбэ хамба Ишбалжир. *Сүмбэ Ишбалжирын Өөрийн намтар оршивой*. Төвд хэлнээс орчуулж, удиртгал тайлбар бичсэн Л.Тэрбиш. Улаанбаатар: 2011, 18

<sup>3</sup> Дагвадорж, Д. *Монголын гүн ухааны мэргэдийн зохиолын цоморлиг*. Улаанбаатар: 1998, 82-83

1737 онд Манжийн Тэнгэрийг тэтгэгч хааны зарлигаар Бээжин хотод очиж эзэн хаан, Жанжаа хутагт, Галдан хийдийн ширээт лам нартай уулзаж, шашин номын хэрэг зөвлөлдсөн боловч, тэдэнтэй санал зөрөлдсөн учир даруй 1738 онд Гонлун хийддээ буцсан ажээ.

1742 онд Бээжин хотод хоёр дахь удаа очиж, Манжийн эзэн хааны дэмжлэгийг олж, буддын шашин-гүн ухааны зохиол бүтээлүүдтэй танилцах, судлах боломжоор хангагдсан байна. Манжийн эзэн хаанаас түүнд Эрдэнэбандид цол хүртээн, шар торгон дээр дарсан батламж бичиг соёрхжээ.

Сүмбэ хамба 1746 онд Гонлун хийдийн тэргүүн хамбаар өргөмжлөгдөж, Алшаа, Ордос, Бээжин, Утай зэрэг олон газруудаар залагдан сууж, ном бүтээлээ туурвиж байжээ. Түүний туурвисан 8 боть сүмбүмд төрөл бүрийн ухааны 68 зохиол байдаг. Тэрээр 1788 онд нас нөгчсөн байна.

### ***Зургаа. Сурвалжийг бичихэд ашигласан хэрэглэгдэхүүн***

Сүмбэ хамба “Галбарваасан модон” зохиолдоо эртний түвэд, хятад, монгол сурвалжуудыг өргөнөөр ашиглажээ. Тус сурвалж бичгийг сайтар нягтлан үзвэл, ямар сурвалжуудыг ашигласан болохыг мэдэж болно. Гэвч, ашигласан сурвалжуудаа нэг бүрчлэн дурдаагүй бөгөөд зарим хэсэгтээ “эртний түвэд, монгол, хятад олон сурвалж бичгүүдэд” гэж ерөнхийлөн бичсэн зүйлүүд нэлээд байна. Тэрээр иш татсан зохиолуудад тэмдэглэгдсэн мэдээ баримтыг нягтлан үзэж, шүүмжлэлтэй ханддаг байжээ.

Тэрээр “Галбарваасан модон” зохиолдоо “Хөх дэвтэр (ᠵᠢᠪᠠᠨᠳᠡᠪᠲᠦᠷ)”, Гунгаадоржийн “Улаан дэвтэр (ᠤᠯᠠᠭᠠᠨᠳᠡᠪᠲᠦᠷ)”, Бутон Ринчэндүвийн “Чойнжин (ᠴᠣᠶᠢᠨᠵᠢᠨ)”, V Далай лам Лувсанжамцын “Өөрийн намтар (ᠥᠭᠡᠮᠡᠳᠦᠨᠠᠮᠲᠠᠷ)”, “Цэнгэсэн судар (ᠴᠡᠩᠭᠡᠰᠡᠩᠰᠤᠳᠠᠷ)”, “Таван үзүүрт уулын судрууд (五台山)”, “Хиргүй охин тэнгэрийн өчсөн судар (ᠬᠢᠷᠭᠡᠢᠬᠡᠨᠠᠶᠢᠨᠲᠡᠩᠭᠡᠷᠢᠨᠥᠴᠢᠰᠦᠨᠰᠤᠳᠠᠷ)”, “Билиг барамидын судар (ᠪᠢᠯᠢᠭᠪᠠᠷᠠᠮᠢᠳᠠᠶᠢᠨᠰᠤᠳᠠᠷ)”, “Оюуны далайг өчсөн судар (ᠣᠶᠤᠨᠠᠳᠠᠯᠠᠢᠭᠡᠢᠬᠡᠨᠰᠤᠳᠠᠷ)”, “Түүнчлэн ирсний нууцыг өгүүлсэн судар (ᠲᠡᠭᠦᠨᠴᠢᠯᠡᠨᠢᠷᠰᠢᠨᠢᠨᠠᠭᠤᠯᠠᠭᠤᠯᠠᠰᠢᠨᠰᠤᠳᠠᠷ)” зэрэг олон сурвалжуудыг ашигласан байна. Эдгээр сурвалж бичгүүдээс гадна ардын үлгэр домог, мөн буддын домог, хутагт хувилгаадын элдэв намтраас ихэд ашиглажээ.

### ***Долоо. Сурвалжийн бүтэц агуулга***

Сүмбэ хамба Ишбалжирын “Галбарваасан модон” зохиолын бүтэц, агуулгын хувьд 5 хэсэгт хуваагдана. Үүнд:

Нэгдүгээр хэсэгт. Бурхан багш өөд болсон, дээд ном номлоод шашин оршсон түүх. Энэ хэсэг нь гурван бүлгээс бүрдэнэ. 1. Ер бурхан аль галавт өөд болох ёсон. 2. Тусгай энэ сайн галавт аль бурхан аль цагт өөд болох ёсон. 3. Ялангуяа Савлувандхадертөнцөд Шагжамуни бурхан өөд болж ном номлосон ёсон. Энэ хэсэгт ертөнц тогтсон ба түүний байгуулалт, галавууд тогтсон болон бурханы эзэлсэн сайн галавын тухай, ялангуяа бурхан хийгээд түүний дагалдагч шавь нарын амьдрал, үйл ажиллагааны тухай, бурхан өөрөө шашныг үндэслэсэн тухай, буддын сургаалын “Их хөлгөн”, “Бага хөлгөн”-ий тухай бурханы сургаалыг бичигт тэмдэглэсэн түүх зэргийг өгүүлсэн байна.

Хоёрдугаар хэсэгт. Энэтхэгийн оронд бурхны шашин дэлгэрсэн түүх. Энэ хэсэг нь гурван бүлгээс бүрдэнэ. 1. Номын хаадын товч. 2. Номын хаадын газар хийгээд тэдгээрийн үед эш үзүүлсэн мэргэн шидтэн алин хийгээд өөд болж шашинд тус үйлдсэн ёсон. 3. Энэтхэгийн орноо зөв ном таны таалал болсон ёсон. Энэ хэсэгт Эртний Энэтхэгийн бурханы шашны томоохон зүтгэлтнүүд, соён гэгээрүүлэгч, шашныг баригч хаад, голлох сүм хийд, ерөнхий орон, дотоод ухааны үүслийн тухай тэмдэглэжээ.

Гурав. Түвэдийн оронд бурханы шашин дэлгэрсэн түүх. Энэ хэсэг нь дөрвөн бүлгээс бүрдэнэ. 1. Түвэд орны газрын байдал хийгээд хийд бүтээлийн орон. 2. Түвэд орны элдэв ёсны үйл. 3. Лозава бандида нар хийгээд ном шастирын орчууга. 4. Мэргэд шидтэний үе зэрэг жилийн чуулганы хүснэгт. Энэ хэсэгт Түвэдэд бурханы шашин үүсч дэлгэрсэн түүх, эртнээс XVIII Түвэдийн түүх, Энэтхэг-Түвэд, Хятад-Түвэд, Түвэд-Монголын харилцаа, Түвэдийн бурханы шашны зүтгэлтэн болон мэргэдийн тухай мэдээ, он дарааллын хүснэгтийг бичсэн байдаг.

Дөрөв. Хятад оронд бурханы шашин дэлгэрсэн түүх. Энэ хэсэг нь хоёр бүлгээс бүрдэнэ. 1. Хаадын үеэс. 2. Бурханы шашин дэлгэрсэн ёсон. Энэ хэсэгт Гурван хуан, Таван ди-гээс Манжийн Тэнгэрийг тэтгэгч хааныг хүртэлх Хятадын хаадын угсаа залгамжилсан түүх, Хятадын бурханы шашны түүхийг тэмдэглэжээ.

Тав. Монгол оронд бурханы шашин дэлгэрсэн түүх. Энэ хэсэг нь хоёр бүлгээс бүрдэнэ. 1. Хаадын үеэс. 2. Бурханы шашин дэлгэрсэн ёсон. Энэ хэсэгт монгол угсаатны бүрэлдэхүүн, эрт үеэс XVIII зууны хүртэлх Монголын хаадын угсаа залгамжлал, Чингис хааны аян дайн, түүний нас нөгчсөн он цаг, шалтгаан, газрын тухай, Юань улс, Сакьяа, гармаагийн хоорондын харилцаа, Монголын олон сүм, хийдийн тухай тодорхой өгүүлжээ.



### *Найм. Бусад сурвалжаас ялгагдах онцлог, ач холбогдол*

Сүмбэ хамба Ишбалжирын “Галбарваасан модон” зохиол нь түвэдийн түүхийн зохиолын томоохон дурсгалуудын дотор чухал байр суурь эзэлдэг бөгөөд дараах хэдэн онцлог, ач холбогдолтой. Үүнд:

1. “Галбарваасан модон” зохиол нь зөвхөн хэмжээний хувьд төдийгүй зохиолд өгүүлсэн түүхэн үйл явдал, хамрагдах шашны үйл явдлаараа түвэд хэлээр бичигдсэн хамгийн том түүхийн зохиол юм.
2. “Галбарваасан модон” зохиол нь түвэд хэлээр бичигдсэн нэлээд сүүл үеийн түүхэн дурсгалд тооцогддог бөгөөд тухайн үеийн зохиолуудад дүгнэлт өгч, тодорхойлсноороо ач холбогдолтой.
3. Сүмбэ хамба Ишбалжир бол өөрийн амьдарч байсан үедээ соёлын хамгийн өндөр түвшинд хүрсэн тал бүрийн боловсрол, мэдлэгтэй хүн байжээ. Гэвч Ишбалжирын ертөнцийг үзэх үзэл нь шашин-гүн ухааны өвөрмөц ойлголттой салшгүй холбоотой байв. Хүний хувь тавилан цаанаасаа зурагдсан гэсэн ойлголт Сүмбэ хамбын ертөнцийг үзэх үзлийн тулгуур болж, мадямакагийн сургаалыг баримтлагч байжээ. Түүний “Галбарваасан модон” зохиолд зохиогчийн ертөнцийг үзэх үзэл нь далд ид шидийн агуулгатай боловч түүний ертөнцийг танин мэдэх, эд зүйлсийн утга учир, түүхийн хөдөлгөөнийг төсөөлөх гэсэн эрмэлзэл илрэх ажээ.
4. Сүмбэ хамбын “Галбарваасан модон” зохиолдоо эртний ба дундад зууны үеийн бурханы шашин дэлгэрсэн Энэтхэг, Түвд, Хятад, Монголын шашин-улс төрийн түүхийг дэлгэрэнгүй өгүүлснээрээ Азийн улс орнуудын түүхэнд төдийгүй дэлхийн түүхэнд ихээхэн хувь нэмэр оруулсан юм. Тэрээр Азийн орнуудын түүхийг бичихдээ ашиглаж болох бүх эх сурвалжуудыг өргөнөөр ашиглаж, өмнөх үеийнхний үзэл бодолд шүүмжлэлтэй хандаж аль нэг улс төр, үндэстэн угсаатан, шашны асуудалд өөрийн гэсэн үзэл бодол, байр суурьтай хандаж байжээ.

**Abstract:** “Dpag-bsam ljon-bzang” which is written by Sumbe Khamba Ishbaljir, is a historical publication in Tibetan through XVIII century. This is biggest historical publication with its historical events or religion events among the Tibetan historical books. This book has studied by Vasilev.P.V, Das. Ch.S, Vostrikov.A.I, Chandra.L, Pubaev.R.E and Bira .Sh, then they defined that is most valuable and important historical publication in Tibetan.